



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИГ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 02

Хэрлэн сум

Компанийн ажилтнуудад 2022 оны жилийн үйл
ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1, 108 дугаар зүйлийн 108.1 дэх хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.17, Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамтын хэлэлцээрийн 3.6, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн а/496 тоот албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг харгалзан ажилтнуудад 2022 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг 3 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээгээр тогтоосугай.
2. Компанийн ажилтнуудад 2022 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдлийг ажлын үр дүнг харгалзан холбогдох журмын дагуу тооцон, батлагдсан санд багтаан олгохыг Гүйцэтгэх захирал /Г.Отгонбаатар/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин, урамшууллын хороо /Г.Бадамцэцэг/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 03

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлын 02 дугаар тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь:

Үүрэг даалгавар өгөх тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны дүгнэлтийг сонсож, 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 02 дугаар тэмдэглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, явц, үр дүнг тайлагнаагүй зөрчил дутагдалтайг дурдаад, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Цалин, урамшууллын хорооны 2022 оны 02 дугаар тэмдэглэлээр өгсөн зөвлөмжийг биелүүлэх, үр дүнг 2023 оны 5 дугаар сард багтаан Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг компанийн гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт даалгав” гэжээ.

ДАРГА



Ж.ЖАНАРБААТАР



“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 02

Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тухай.

ТЭМДЭГЛЭСЭН НЬ:

Компанийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Гэрэлчулуун танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Тус компаний 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” ХХК-ийн дүгнэлт гарч баталгаажсаны дараа Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд дахин танилцуулахыг Гүйцэтгэх захирал Г.Отгонбаатарт үүрэг болгов” гэжээ.

ДАРГА

Ж.ЖАНАРБААТАР

